




1

ХҮҮХЭД ГЭЖ ХЭН БЭ?



2

ЯЛГАВАРЛАН
ГАДУУРХАХГҮЙ
БАЙХ

3

ХҮҮХДИЙН ЭРХ
АШГИЙГ ДЭЭДЛЭХ

4

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ
БОДИТООР
ХЭРЭГЖҮҮЛЭХ


5

ГЭР БҮЛИЙН ЗҮГЭЭС
ХҮҮХДЭЭ ДЭМЖИХ

6

ЭСЭН МЭНД ТӨРЖ,
ӨСӨЖ, ХӨГЖИХ ЭРХ

7

ОВОГ НЭР, ИРГЭНИЙ
ХАРЬЯЛАЛТАЙ БАЙХ
ЭРХ

8

АЛБАН ЁСНЫ
БҮРТГЭЛТЭЙ БАЙХ
ЭРХ

9

ЭЦЭГ ЭХТЭЙГЭЭ ХАМТ
БАЙХ ЭРХ

10

ГАДААДАД БАЙГАА
ЭЦЭГ, ЭХТЭЙГЭЭ
УУЛЗАХ, ХАМТ БАЙХ
ЭРХ

11

ХҮҮХДИЙГ ХУУЛЬ
БУСААР ХИЛ
ДАМНУУЛАН АВЧ
ГАРАХААС ХАМГААЛАХ


12

ХҮҮХДИЙН ҮЗЭЛ
БОДЛЫГ ХҮНДЭТГЭХ

13

ҮЗЭЛ БОДЛОО
ЧӨЛӨӨТЭЙ
ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ

14

ИТГЭЛ ҮНЭМШИЛТЭЙ
БАЙХ, ШАШИН ШҮТЭХ
ЭРХ

15

ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ
ЭРХ

16

ХҮВИЙН НУУЦТАЙ
БАЙХ ЭРХ

17

МЭДЭЭЛЭЛ
АВАХ ЭРХ

18

ЭЦЭГ, ЭХ ХҮҮХДЭЭ
ӨСГӨЖ,
ХҮМҮҮЖҮҮЛЭХ
ҮҮРЭГТЭЙ

19

ХҮЧИРХИЙЛЛЭЭС
ХАМГААЛУУЛАХ ЭРХ

20

ГЭР БҮЛТЭЙГЭЭ
АМЬДРАХ БОЛОМЖГҮЙ
ХҮҮХДИЙН ЭРХ


21

ҮРЧЛЭГДСЭН
ХҮҮХДИЙН ЭРХ


22

ДҮРВЭГЧ ХҮҮХДИЙН
ЭРХ

23

ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮҮХДИЙН ЭРХ

24

ЭРҮҮЛ МЭНД, УС,
ХООЛ ХҮНС,
ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН

25

АСРАМЖИД БАЙГАА
ХҮҮХДИЙН НӨХЦӨЛ
БАЙДЛЫГ ТОГТНОЛ
ХЯНАХ


26

НИЙГМИЙН ХАЛАМЖ
АВАХ ЭРХ


27

ХООЛ ХҮНС, ХУВЦАС,
АЮУЛГҮЙ ГЭР ОРОН

28

СУРЧ БОЛОВСРОХ
ЭРХ

29

ХҮҮХДИЙН ЧАДАВХЫГ
БҮРЭН ТӨГС
ХӨГЖҮҮЛЭХ


30

ЦӨӨНХИЙН ХЭЛ, СОЁЛ,
ШАШИН ШҮТЛЭГ

31

АМРАХ, ТОГЛОХ, СОЁЛ
УРЛАГИЙН АРГА
ХЭМЖЭЭНД ОРОЛЦОХ
ЭРХ

32

ХҮҮХДИЙГ АЮУЛТАЙ
АЖИЛ ХИЙХЭЭС
СЭРГИЙЛЭХ

33

МАНСУУРУУЛАХ БОЛОН
СЭТГЭЦЭД НӨЛӨӨТЭЙ
БОДИСООС ХАМГААЛАХ

34

ХҮҮХДИЙГ БЭЛГИЙН
ХҮЧИРХИЙЛЛЭЭС
ХАМГААЛАХ


35

ХҮҮХДИЙГ
ХУДАЛДАХААС
ХАМГААЛАХ


36

ХҮҮХДИЙН
МӨЛЖЛӨГӨӨС
ХАМГААЛАХ


37

ЭРХ ЧӨЛӨӨГӨӨ
ХАСУУЛСАН
ХҮҮХДИЙН ЭРХ

38

ХҮҮХДИЙГ ЗЭВСЭГТ
МӨРГӨЛДӨӨНӨӨС
ХАМГААЛАХ

39

ХОХИРОГЧ ХҮҮХДИЙГ
НӨХӨН СЭРГЭЭХ,
НИЙГЭМД НЭГТГЭХ

40

ШУДАРГА ХУУЛЬ ЭРХ
ЗҮЙН ОРЧИН

41

ХҮҮХДЭД ИЛҮҮ
ЭЭЛТЭЙ ХУУЛИЙГ
МӨРДӨХ

42

ХҮН БҮР ХҮҮХДИЙН
ЭРХИЙН ТУХАЙ
МЭДДЭХ БАЙХ

43-54

ХҮҮХДИЙН ЭРХИЙН
ТУХАЙ КОНВЕНЦ
ХЭРХЭН ХЭРЭГЖДЭГ
ТУХАЙ ЗААЛТУУД

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ

Хүүхэд бүр эсэн мэнд өсөж хөгжих эрхтэй. 7	Хүүхэд бүр эсэн мэнд өсөж хөгжих эрхтэй. 6	Эцэг, эх асран хамгаалагчид нь хүүхдийг эрхээ эдлэхэд нь туслах, эрхийг нь хамгаалах үүрэг хүлээдэг. 5	Хүүхдийн эрх бүх түвшинд хамгаалагдаж байгаа эсэхэд төр хяналт тавьж ажиллах үүрэгтэй. 4	Хүүхдийн сайн сайханд нийцэх эсэхийг тооцож байж шийдвэр гаргах ёстой. 3	Хүүхэд бүр энэ конвенцод заасан эрхүүдийг эдэлнэ. Хүүхэд бүр хэн болох, хаана амьдардаг, эцэг эх, асран хамгаалагч нь хэн болох, ямар ажил хийдэг, ямар хэлээр ярьдаг, ямар шашин шүтдэг, эрэгтэй эмэгтэй, соёл, хөрөнгө чинээ, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран энэ конвенцод заасан бүх эрхийг тэгш эдлэх эрхтэй. 2	18 хүртэлх насны бүх хүнийг хүүхэд гэнэ. 1
Хүүхэд чөлөөтэй сэтгэн бодох, ухамсарлах, шашин шүтлэг, итгэл бишрэлээ өөрөө сонгох эрхтэй. 14	Хүүхэд өөрийн мэдлэгээ ашиглан ямар нэг зүйлд баригдахгүйгээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөртөө болон бусдад хохирол учруулахгүй бол бүх хэлбэрээр (ам болон бичгээр, зургаар болон бусад аргаар) мэдээлэл цуглуулах, мөн шинэ санаа гаргах эрхтэй. 13	Хүүхэд бүр үзэл бодолтой байж, түүнийгээ илэрхийлэх бүрэн эрхтэй. Хүүхдийн асуудлаар шийдвэр гаргахад хүүхдийн үзэл бодлыг сонсож, ач холбогдол өгч харгалзан үзэх ёстой. 12	Төр хүүхдийг хулгайлагдах, худалдагдахаас хамгаалах үүрэгтэй. 11	Хүүхэд эцэг, эхээсээ өөр улсад байгаа тохиолдолд бол эцэг, эхтэйгээ очиж уулзах, тэдэнтэй хамт амьдрах эрхтэй. 10	Хүүхдэд хор уршиг учрахаас бусад тохиолдолд хүүхэд бүр эцэг, эхтэйгээ амьдрах эрхтэй. Эцэг, эхийнхээ аль нэгнээс нь салж тусгаарлагдсан тохиолдолд эцэг, эхийнхээ аль алинтай нь хувийн болон шууд харилцаатай байх эрхтэй. 9	Хүүхэд бүр нэр, иргэншил, гэр бүлийн холбоо зэрэг хувийн онцлог байдлаа хадгалах эрхтэй. Төр нь хүүхдийн иргэний харьяаллыг хамгаалах үүрэгтэй. 8
Зөвхөн хүүхдийн сайн сайхны төлөө эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр хүүхдийг үрчлүүлж болно. 21	Өөрийн гэр бүлээс түр буюу бүрмөсөн хагацсан, эсвэл гэр бүлийнхээ дотор цаашдаа эсэн мэнд өсөж хөгжихөд нь харшлах аюултай болбол хүүхэд бүр асрамжлан хамгаалуулах тусламж авах эрхтэй. 20	Төр хүүхдийг хүчирхийлэх, үл хайхрах явдлын бүх хэлбэр, хүүхэдтэй зүй бусаар харьцах явдлаас хамгаалах үүрэгтэй. 19	Эцэг эх нь хүүхдээ хамтран өсгөх үүрэгтэй. Эцэг эхийн үүргээ биелүүлэхэд нь төр зохих дэмжлэг үзүүлнэ. 18	Хүүхэд өөрт тустай мэдээллийг ном, сонин, сэтгүүл, радио, телевиз болон бусад хэрэгслийг ашиглан олж авах эрхтэй. Төр хор хөнөөлтэй мэдээллээс хүүхдийг хамгаалах арга хэмжээ авна. 17	Хүүхэд бүр хувийн нууцтай байх эрхтэй. 16	Хүүхэд найзаа сонгох эрхтэй. Бусдын эрх, эрх чөлөөнд харшлахгүйгээр эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх эрхтэй. 15
Хүүхэд сурч боловсрох эрхтэй. Хүүхдэд бага боловсролыг үнэ төлбөргүйгээр заавал эзэмшүүлэх, дунд шатны боловсролын янз бүрийн хэлбэрийг бүх хүүхдэд хүртээмжтэй байлгахад анхаарах, хүүхдийн чадвараас нь хамааран дээд боловсрол эзэмших эрхийг нь хангах нь төрийн үүрэг юм. 28	Хүүхэд бүр амьдралын суурь хэрэгцээг хангах хоол хүнс, хувцас, аюулгүй амьдрах орчноор хангагдах эрхтэй. 27	Төрөөс нийгмийн халамж, анхаарал шаардлагатай, ядуу өрхийн хүүхдэд тусламж үзүүлнэ. 26	Халамж, хамгаалал үзүүлэх, эсвэл эмчилгээ хийх зорилгоор төрөөс хүүхдийг өөр газарт шилжүүлэн байршуулсан тохиолдолд тус газраас үзүүлж байгаа үйлчилгээнд тогтмол үнэлгээ хийх байх ёстой бөгөөд хүүхэд ийм эрхтэй. 25	Хүүхэд чанартай сайн эрүүл мэндийн үйлчилгээ, зөвлөгөө мэдээлэл авах, үндны цэвэр ус, тэжээллэг хоол хүнсээр хангагдаж, цэвэр аюулгүй орчинд аж төрөх эрхтэй. 24	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь нэр төртэй амьдралын сайн сайхныг бүрэн эдлэхийн тулд тусгай халамж, боловсролд хамрагдаж боломжтой хэмжээгээр бие даах, нийгэмших эрхтэй. 23	Төр дүрвэн ирэгч хүүхдийг эцэг эхтэй нь эргэн нэгтгэхэд анхаарч ажиллах ба эдгээр хүүхдүүд тус улсын бусад хүүхэдтэй адил эрх эдэлнэ. 22
Хүүхдийг худалдах, хулгайлах, хууль бусаар хил давуулах явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төрөөс заавал авч хэрэгжүүлнэ. 35	Төр нь хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамтын ямар нэгэн хэлбэрт өртүүлэхээс хамгаална. 34	Хүүхэд мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх, үйлдвэрлэх болон борлуулахад оролцохоос хамгаалагдах эрхтэй. 33	Хүүхэд өөрийн эрүүл мэнд, боловсрол хөгжилд мүүгаар нөлөөлөх аливаа хөдөлмөр эрхлэхээс хамгаалагдах эрхтэй. Хөдөлмөрлөдөг хүүхдийн ажлын орчин аюулгүй байх ёстой бөгөөд хөдөлмөрийг нь шударгаар үнэлсэн цалин хөлс авах эрхтэй. 32	Хүүхэд чөлөөт цагаараа тоглон наадаж, соёлын болон урлагийн үйл ажиллагаануудад оролцох эрхтэй. 31	Үндэсний цөөнх хүн амын хүүхдүүд үндэснийхээ соёлыг эзэмших, шашин шүтэх, төрөлх хэлээ сурч хэрэглэх эрхтэй. 30	Боловсрол нь хүүхдийн хувийн онцлог чанар, авьяас, оюун ухаан, биеийн чадварыг бүрэн хөгжүүлэх зорилготой. Боловсрол нь хүүхдийг насанд хүрсэн хойноо нийгэмд харилцан ойлголцол, зөвшилцлийг дээдэлдэг, ялгаварлан гадуурхлаас ангид, идэвхтэй амьдардаг, эцэг эх, уг гарал, хэл соёл, үнэт зүйлээ ойлгож хүндэтгэдэг хүн болоход бэлтгэнэ. 29
Хүүхэд эрхээ мэдэх эрхтэй. Насанд хүрэгчид хүүхдийн эрхүүдийг мэддэг байх ёстой бөгөөд эрхээ мэдэхэд нь хүүхдэд туслах үүрэгтэй. 42	Тухайн улсын хууль тогтоомж нь хүүхдэд энэхүү Конвенцын зүйл заалтаас илүү боломж олгож байвал тэдгээр хуулийг дагаж мөрдвөл зохино. 41	Хүүхэд эрхээ хамгаалуулах, өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх боломжоор хангагдаж, өөрийнх нь эрхийг хүндэтгэн үздэг шударга эрх зүйн тогтолцоогоор үйлчлүүлэх эрхтэй. 40	Төр нь хүчирхийлэл, үл хайхрах явдал болон бусад зүйл бус харилцаанаас хохирсон хүүхдэд бие бялдар, сэтгэл санааны нөхөн сэргээх арга хэмжээг авч, нийгмийн амьдралд буцан ороход нь боломжтой бүх хэлбэрээр дэмжлэг үзүүлнэ. 39	Төр нь зэвсэгт мөргөлдөөний хохирогч болсон хүүхдүүдийг хамгаалах, асран халамжлах бололцоотой бүх арга хэмжээг авна. 38	Хүүхдийг тамлан зовоох, харгис хэрцгийгээр шийтгэх, хууль бусаар баривчлах, эрх чөлөөг нь хязгаарлах эрх хэнд ч байхгүй. 37	Хүүхдийг хохироох бүх төрлийн мөлжлөг, хүүхдийг ашиглах явдалтай төр тэмцэх үүрэгтэй. 36

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙН КОНВЕНЦ ХЯЛБАРШУУЛСАН ХУВИЛБАР

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухайн конвенц нь дэлхийн улс орнууд хүүхдийнхээ эрхийг сахин хамгаалахаа амласан чухал хэлэлцээр юм.

Хүүхдийн эрхийн тухайн конвенцод хүүхэд гэж хэнийг хэлэх, тэд ямар эрх эдлэх, тэдгээр эрхийг хэрэгжүүлэхэд төр ямар үүрэгтэйг тайлбарласан байдаг. Хүүхдийн бүх эрх хоорондоо салшгүй холбоотой, бүгд эн тэнцүү ач холбогдолтой, тэдгээрийг хүүхдээс булаан авах эрх хэнд ч байхгүй.

Эдгээр зүйл заалтуудын дагуу тухайн улсын төр болон олон улсын байгууллагууд хүүхдийн эрхийг хамгаалж, хангахын төлөө ажиллана.

43-54